

ГАМШГИЙН АЮУЛЫН ТУХАЙ ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР АЖИЛЛАХ ДАДЛАГА сургалтад БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИД ИДЭВХТЭЙ ОРОЛЦЛОО

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг баталж, жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх 7 хоногийн Пүрэв гаригийн 16:00 цагаас улс орон даяар гамшгийн аюулын зарлан мэдээлэх дохиогоор ажиллах сургалт, дадлага сургуулийг зохион байгуулж явуулдаг. Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс улс орон даяар зарлан мэдээллийн дохиог 3 удаа дамжуулах үед:

- Нэгдэх дохио дуугарахад “суу, нүүгд, хүлээ” гэсэн дүрмийг баримталж аль болох шил, цонхноос хол, бат бөх ширээн доогуур орж бие болон толгойгоо халхлан аюулгүй байдлаа хангаж түр хүлээх,
- Хоёр дахь дохио дуугарахад толгойгоо халхлан яарч сандралгүй нэгийн цуваанд орж баруун гар талаа барьж, “гүйхгүй, эргэж буцахгүй, нэгнээ түлхэхгүй” гарч, аюулгүй талбайд цуглах,
- Гурав дахь дохио дуугарахад та байгууллагынхаа холбогдох албан тушаалтанд бүртгүүлж, хамт олны мэдээллийг үнэн зөв тодорхой өгөх гэсэн дүрмийг баримтлан “ГТХЗНТ” УТҮГ-ын албан хаагчид өөрт ойр байгаа аюулгүйн цугларах талбайд гарч, дадлага сургуульд идэвхтэй оролцлоо.